

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ НЬ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛНА. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСНӨӨР ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААНД ОРОЛЦОХ ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫГ ХҮЛЭЭХЭЭР ТАЛУУД ТОХИРОЛЦСОНД ТООЦОГДОНО.

### НЭГ. ҮГ ХЭЛЛЭГИЙН ТАЙЛБАР

№	Үг, хэллэг	Тайлбар
1	Суперкасс програм	ОДО ЭКОСИСТЕМС ХХК-ийн брэнд бүтээгдэхүүн болох кассын програм
2	Үйлчилгээ	Кассын програмыг ашиглах үйлчилгээ
3	Үйлчилгээ үзүүлэгч	Суперкасс програмыг хариуцан, үйлчилгээ үзүүлж буй ОДО ЭКОСИСТЕМС ХХК
4	Үйлчилгээний нөхцөл	Үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулах цахим баримт бичиг
5	Хэрэглэгч	Суперкасс програмыг ашиглаж буй хувь хүн эсвэл хуулийн этгээд
6	Талууд	Үйлчилгээ үзүүлэгч болон Хэрэглэгч

### ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Үйлчилгээний нөхцөл нь Хэрэглэгч Үйлчилгээний нөхцөлтэй танилцан хүлээн зөвшөөрч систем баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.
2. Үйлчилгээний нөхцөлд Үйлчилгээний төлбөр, тооцоотой холбоотой “Төлбөрийн нөхцөл” баримт бичгийг хавсаргасан. Энэ нь Үйлчилгээний нөхцөлийн бүрэлдэхүүн хэсэг тул Үйлчилгээний нөхцөлтэй танилцаж, зөвшөөрсөн нь тус баримт бичигтэй танилцсанд тооцогдоно.
3. Суперкасс програм нь оюуны өмчийн эрхтэй бүтээгдэхүүн бөгөөд Монгол Улсын “Оюуны өмчийн тухай” хуулиар хамгаалагдана.
4. Суперкасс програм болон Үйлчилгээтэй холбоотой вэб сайт, түүний мэдээлэл, баримт бичиг нь Үйлчилгээ үзүүлэгчийн өмч юм.
5. Суперкасс програм нь “Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем”-д холбогдон ажиллах бөгөөд зөвхөн сугалаатай баримт хэвлэнэ. Өөр бусад зорилгоор ашиглах боломжгүй бөгөөд төхөөрөмж болон ашиглалтаас 100% хамаарах тул баталгаа гаргахгүй болно.

### ГУРАВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

1. Хэрэглэгч Үйлчилгээний нөхцөл болон Төлбөрийн нөхцөлтэй танилцаж зөвшөөрснөөр дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.
2. Хэрэглэгч нь өөрийн байгууллагын талаарх мэдээллийг програм суурилуулах зориулалтаар үйлчилгээ үзүүлэгчид өгөх үүрэгтэй бөгөөд байгууллагын талаарх мэдээлэлд өөрчлөлт орвол үйлчилгээ үзүүлэгчид цаг алдалгүй мэдэгдэх мөн мэдээлэл ба өгөгдлийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээнэ.
3. Хэрэглэгч нь програм суурилуулах компьютер, сервер, төхөөрөмж, интернэт сүлжээг бэлтгэж ашиглах үүрэгтэй.
4. Хэрэглэгч нь програм суурилуулан анх хүлээн авахдаа ашиглах заавар, зөвлөмж сургалтыг 1 (нэг) удаад авах ба цаашид програм ашиглах хүн (кассчин, худалдагч гм) нь солигдох тохиолдол бүрт хэрэглэгч өөрөө ашиглах заавар, зөвлөмжийг өгөх; гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүй байдлаар програм суурилуулсан компьютер, сервер, мобайл төхөөрөмжийг дамжуулсан, ашиглуулсан, хэрэглүүлсэн, буруу ажиллуулснаас үүсэн гарах аливаа үр дагавар, хохирол, зардлыг өөрөө хариуцах үүрэгтэй.
5. Хэрэглэгч нь Үйлчилгээг ашиглан хийсэн бүхий л үйлдэлд хариуцлага хүлээнэ.
6. Хэрэглэгч Үйлчилгээ үзүүлэгчийн шинээр танилцуулсан, програмтай холбогдсон бусад нэмэлт системүүдийг заавал ашиглах үүрэгтэй.

7. Хэрэглэгч нь програмын алдааг засварлуулах эрхтэй ба өөрийн ашиглалтын буруугаас үүдсэн буюу дор дурдсан аливаа асуудлаар үйлчилгээ үзүүлэгчид төвөг учруулахгүй байх үүрэгтэй.
  - Интернет холболт
  - Нэвтрэх нэр, нууц үг лавлах
  - Компьютер, кассын төхөөрөмжийн цаг таараагүй гм өөр бусад програмаас шалтгаалаагүй бүх тохиргоо
  - Хэвлэгч принтер ажиллахгүй, тасалдалтай хэвлэх, гацах гм хэвлэгч принтертэй холбоотой бүх асуудлууд

## **ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ,ҮҮРЭГ**

1. Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн компьютер, сервер, төхөөрөмжид програмыг суурилуулан, ажиллагааг шалган, нэг удаагийн зааварчилгаа сургалт өгч хүлээлгэн өгнө.
2. Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн програм суурилуулах компьютер, сервер төхөөрөмжийг бэлтгэн ашиглуулах үүрэг хүлээхгүй.
3. Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчид програм алдааг засварлан өгөх үүрэгтэй ба хэрэглэгчийн ашиглалтын буруутай үйлдэл /3.7-д заасан/ програмын алдаанаанаас бусад алдааг засварлан өгөхгүй байх эрхтэй.
4. Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчийн байгаа байрлалд биечлэн очиж тусламж, дэмжлэг үзүүлэхгүй.
5. Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчийн интернет холболтоос /3.7-д заасан/ үүдэлтэй асуудалд үйлчилгээ үзүүлэх болон хариуцлагыг хүлээхгүй.
6. Хэрэглэгч нь өөрийн буруутай ашиглалтын улмаас програм гэмтээх болон устгасан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч хариуцлага хүлээхгүй.
7. Үйлчилгээ үзүүлэгч нь Үйлчилгээний нөхцөл, Төлбөрийн нөхцөлд хэдийд ч өөрчлөлт оруулах эрхтэй.
8. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү Үйлчилгээний нөхцөлд тусгагдаагүй боловч хуулиар олгогдсон бусад эрхээ хэрэгжүүлж болно.
9. Үйлчилгээ үзүүлэгч нь програмын хөгжүүлэлт, шинэчлэлтийг хэрэглэгчийн програмд тусган шинэчлэх эрхтэй.
10. Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн програмаас хэвлэгдэн гарах баримтын нүүр болон ар талд өөрийн таних тэмдэг (лого) болон бусад мэдээллийг байршуулан хэвлэх эрхтэй.
11. Үйлчилгээ үзүүлэгч нь 3.2-д заасан мэдээлэл ба өгөгдлийн үнэн зөв байдлаас шалтгаалан хэрэглэгчид хохирол учирсан тохиолдолд хариуцлага хүлээх үүрэггүй.
12. Үйлчилгээ үзүүлэгч нь төрийн эрх бүхий байгууллагын шаардсанаар хэрэглэгчийн програмын ашиглалтыг хязгаарлах эрхтэй.
13. Програмаас үл шалтгаалсан компьютер, сервер, төхөөрөмжийн болон сүлжээний гэмтэл, механик гэмтэл, хэрэглэгчийн ашиглалтын гэмтэл зэрэгт үйлчилгээ үзүүлэгч хариуцлага хүлээх үүрэггүй.

## **ТАВ. АСУУДАЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

1. Програм дээр гарсан програмын алдааг үйлчилгээ үзүүлэгч хэрэглэгчийн компьютер, сервер төхөөрөмжид сүлжээгээр буюу интернет TEAM VIEWER програмаар холбогдон засварлах ба шаардлагатай тохиолдолд хэрэглэгч үйлчилгээ үзүүлэгчийн ажлын байранд ирж засвар үйлчилгээг авна.
2. Хэрэглэгч нь Үйлчилгээний нөхцөлөөр хүлээсэн үүргээ зөрчсөн, Үйлчилгээг хууль бусаар ашигласан, Үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд болон бусад Хэрэглэгчдэд хохирол учруулсан нь батлагдвал Хэрэглэгчийн эрхийг цуцална.
3. Давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон нөхцөлд талууд гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлээс тухайн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан нөхцөл байдал үргэлжлэн дуусах хүртэлх хугацаанд чөлөөлөгдөнө. “Давагдашгүй хүчин зүйлс” гэдэгт талуудын хамаарч шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал, түүнд өртсөн талуудын урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс үл хамааран учирч буй нөхцөл байдлыг хамааруулна.
4. Үйлчилгээтэй холбоотой санал, гомдол, асуудал, маргааныг Талууд эв, зүйгээр харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Хэрэв шийдвэрлэх боломжгүй бол Монгол Улсын хууль, тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.
5. Талууд харилцан итгэлцэж хамтран ажиллана.

## ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Төлбөр тооцоотой холбоотой асуудлыг “Төлбөрийн нөхцөл”-өөр зохицуулна.

1. Үйлчилгээ үзүүлэгч нь бүртгэлийн хураамж, нэмэлт ажил үйлчилгээний үнэ болон Үйлчилгээний нөхцөлд хэдийд ч өөрчлөлт оруулах эрхтэй байна. Өөрчлөгдөж байгаа мэдэгдэл мэдээллээс хамааруулан өөрчлөлтийг үйлчилгээ үзүүлэгчийн вэб хуудас, олон нийтийн сүлжээний хуудас, шаардлагатай тохиолдолд утсаар дамжуулан ажлын 2/хоёр/-с доошгүй хоногийн өмнө мэдээллэнэ.
2. Өөрчлөлт орсноос хойш хэрэглэгч хамгийн багадаа 2(хоёр) сар дотор програмыг ашигласаар байгаа бол өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
3. Үйлчилгээний төлбөрт НӨАТ орсон болно.

№	Утга	Төлбөр
1	Бүртгэлийн хураамж	50.000 ₮
2	Дахин суулгалт	35.000 ₮
3	Дахин сургалт авах	15.000 ₮
4	Нэр солих, нэр шилжих	50.000 ₮

4. Төлбөрийг дараах байдлаар төлнө.

Харилцах банк	Дансны дугаар	Гүйлгээний утга
ХААН БАНК	5121 025 148	Байгууллага, Иргэний Регистрийн дугаарыг үнэн, зөв, тодорхой бичих
ГОЛОМТ БАНК	3635 10 4889	

5. Програм ашиглахаа болих тохиолдолд үйлчилгээний төлбөрийг буцаан олгохгүй.
6. Програм ашиглахаа болих тохиолдолд бусад дагалдах хэвлэгч принтер, бар код уншигч гм тоног төхөөрөмжүүдийн төлбөрийг буцаан олгохгүй.
7. Үйлчилгээний төлбөр, тооцоотой үүссэн маргааныг талууд эв, зүйгээр шийдвэрлэнэ. Хэрэв маргааныг шийдвэрлэх боломжгүй бол Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.